2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,444,100.00	66,004,500.00	8,439,600.00	88.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,900,000.00	40,550,000.00	350,000.00	99.1
210604	Урсгал засвар	33,544,100.00	25,454,500.00	8,089,600.00	75.9
2107	Томилолт, зочны зардал	3,434,600.00	3,381,900.00	52,700.00	98.5
210702	Дотоод албан томилолт	3,434,600.00	3,381,900.00	52,700.00	98.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,174,800.00	3,537,871.00	1,636,929.00	68.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,893,400.00	1,662,000.00	231,400.00	87.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	390,000.00	378,000.00	12,000.00	96.9
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	170,775.00	329,225.00	34.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	501,000.00	235,256.00	265,744.00	47.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	230,000.00	49,572.00	180,428.00	21.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,400.00	702,500.00	617,900.00	53.2
210807	Газрын төлбөр	340,000.00	339,768.00	232.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,655,600.00	42,701,300.00	16,954,300.00	71.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,206,100.00	33,117,100.00	16,089,000.00	67.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,449,500.00	9,584,200.00	865,300.00	91.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,301,500.00	62,249,700.00	51,800.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,301,500.00	62,249,700.00	51,800.00	99.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	16,737,300.00	0.00	100.0

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,064,600.00	39,064,600.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,499,600.00	6,447,800.00	51,800.00	99.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	309,916,000.00	246,108,755.00	63,807,245.00	79.4
223001	Бусад хөрөнгө	309,916,000.00	246,108,755.00	63,807,245.00	79.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	180,000,000.00	109,200,000.00	70,800,000.00	60.7
230001	Эргэж төлөгдөх зээл	180,000,000.00	109,200,000.00	70,800,000.00	60.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,651,148,100.00	1,473,520,900.00	177,627,200.00	89.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	140,298,000.00	133,298,000.00	7,000,000.00	95.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	140,298,000.00	133,298,000.00	7,000,000.00	95.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,273,439,200.00	1,248,399,570.00	25,039,630.00	98.0
320001	Орон нутгийн төсвөөс	1,273,439,200.00	1,248,399,570.00	25,039,630.00	98.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	237,410,900.00	91,823,330.00	145,587,570.00	38.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	83,440,000.00	91,823,330.00	-8,383,330.00	110.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	153,970,900.00	0.00	153,970,900.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	220,137,909.22	0.00	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	139,603,703.22	0.00	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	144.00	144.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00		
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	71.00	71.00		
620001	Удирдах ажилтан	10.00	10.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00		
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00		
620004	Гэрээт ажилтан	48.00	48.00		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	71.00	71.00		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	45.00	45.00		
650010	Гэрээт ажилтан	6.00	5.00		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,359,650.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,359,650.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,557,258.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,000,000.00
210104	Урамшуулал	2,000,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,195,558.00
210301	Гэрэл, цахилгаан	1,295,558.00
210302	Түлш, халаалт	900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,811,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,261,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,550,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,950,000.00
210602	Тавилга	4,950,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,802,392.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,802,392.50
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	512,866.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,289,526.50
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,070,124.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,070,124.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00
131103	ЗГНХ, ЗДНХ өрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,361,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,708,424.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-1,289,526.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,289,526.50

3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлж, Төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 245.9 сая төгрөг болж, өмнөх оноос 168.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Хувь
Төрийн сангийн харилцах	414.4	245.9	-168.5	59.3
Дүн	414.4	245.9	-168.5	59.3

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 245.9 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 106.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 49.5 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 90.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 202.0 сая төгрөг болж 50.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	160.5	199.3	38.8
Төлбөрт үйлчилгээний авлага	64.5	0.00	-64.5
Зээлийн хүүгийн авлага	2.0	2.3	0.3

Байгууллагаас авах авлага	25.5	0.4	-25.1
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	0.0	0.0	0.0
Дүн	252.5	202.0	-50.5

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022_оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурахад Эрүүл мэндийн төвийн авлага 39.2 сая төгрөг, Цэцэрлэгийн авлага 14.0 сая, төгрөгөөр буурсан нь голчлон нөлөөлжээ. Мөн Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага өссөн байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 382.1 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 132.4 сая төгрөг болж 249.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	14.1	0.0	-14.1
Бичиг хэргийн материал	6.0	1.6	-4.4
Аж ахуйн материал	226.9	24.6	-202.3
Сэлбэг хэрэгсэл	3.8	0.0	-3.8
Түлш шатах тослох материал	4.0	0.0	-4.0
Барилгын засварын материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	22.7	0.0	-22.7
Бусад хангамжийн материал	104.3	98.2	-6.2
Мал амьтад	0.0	7.9	7.9
Дүн	382.1	132.4	-249.7

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсвийн байгууллага болох Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэгийн бараа материалыг шилжүүлж тайлагнасангай холбоотой бараа материалын үлдэгдэл буурсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,799.7 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 2,186.1 сая төгрөг болж 8,613.6 сая төгрөгөөр буурсан байна

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	8,018.5	477.3	-7,541.2
Хуримтлагдсан элэгдэл	-1,009.7	-133.9	-875.8
Авто тээврийн хэрэгсэл	481.5	321.3	-160.2

Хуримтлагдсан элэгдэл	-150.9	-117.3	-33.6
Машин тоног төхөөрөмж (компьютер)	834.6	214.4	-620.2
Хуримтлагдсан элэгдэл	-579.5	-116.9	-462.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	353.0	63.3	-289.7
Хуримтлагдсан элэгдэл	-225.3	-37.6	-187.7
Зам, гүүрийн байгууламж	194.6	194.6	0.0
Хуримтлагдсан элэгдэл	0.0	0.0	0.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	43.2	0.0	-43.2
Бусад үндсэн хөрөнгө	606.0	852.3	246.3
Хуримтлагдсан элэгдэл	-160.4	-216.7	56.3
Программ хангамж	3.5	2.0	-1.5
Хуримтлагдсан элэгдэл	-3.1	-1.7	-1.4
Бусад биет бус хөрөнгө	224.8	60.7	-164.1
Хуримтлагдсан элэгдэл	-29.0	-24.0	-5.0
Дүн	10,799.7	2,186.1	-8,613.6

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,186.1 сая төгрөг болж 8,613.6 сая төгрөгөөр буурахад гүйцэтгэлээр санхүүжих улсын төсөвт байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээс голчлон нөлөөлсөн байна. Тайлант онд худалдан авсан хөрөнгө 65.5 сая, бусад эх үүсвэрээс 338.3 сая, нийт 403.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр 8,985.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 16.0 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэлгүй болж 21.4 сая төгрөг болж 5.4 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбоотой өглөг	0.0	0.0	0.0
Байгууллагад төлөх өглөг	16.0	21.4	5.4
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	0.0	0.0
Татварын өглөг	0.0	0.0	0.0
НДШ өглөг	0.0	0.0	0.0
Нийт дүн	16.0	21.4	5.4

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022_ оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй 21.4 сая төгрөг болж 5.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь шинээр ашиглалтад орсон спорт заалны халаалтын өр төлбөр байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 9,416.1 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 3,195.5 сая төгрөг болж 6,230.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,398.3	350.6	-2,047.7
Хуримтлагдсан үр дүн	5,309.8	1,430.8	-3,879.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,966.6	315.1	-1,651.5
Дүн	9,674.9	2,096.6	-7,578.3

Эх сурвалж: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022_ оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,096.6 сая төгрөг болж 7,578.3 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээ буурснаас шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 317.2 сая, татварын бус орлого 417.7 сая, тусламж санхүүжилтийн орлого 2,241.1 сая, нийт 2,976.0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 0.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

ИТХ нь Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогыг 5.7 сая, мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг 5.7 сая, орлогыг нийт 11.4 сая төгрөгөөр буруу илэрхийлснийг аудитын явцад залруулга хийлсэн.

Тариалан сумын засаг даргын тамгын газар:

Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 3.0 сая төгрөгийг ажилчдын амралт сувилалд зориулж төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, арвиан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16.5.5 дахь заалтад "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дах хэсэгт "ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал", гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Тариалан сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 9/01 дүгээр тогтоолд Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 334.3 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 328.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 98.1 хувиар биелүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд нийт 1,651.1 сая төгрөгийн санхүүжилт авахаас аймгийн орон нутгийн төсвөөс 784.9 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 154.1 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгээр 140.2 сая, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 100.0 сая, татварын болон татварын бус орлогоос 334.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тариалан сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 6/01 дүгээр тогтоолоор 1,801.7 сая төгрөгөөр баталж 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 9/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 150.3 сая төгрөгөөр бууруулж 1,651.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,651.4 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 1,273.4 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 153.9 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 140.3 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 83.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,248.4 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 133.3 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 91.8 сая төгрөгийг санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,466.2 сая төгрөгийг зарцуулж, 57.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,466.2 сая төгрөг буюу 88.8 хувьтай байгаа нь зардлыг 57.5 сая төгрөгөөр хэмнэж, гүйцэтгэлээр ОНХС-аас 7.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу хийгдэж, Орон нутгийн татварын орлого 5.6 сая төгрөгөөр дутуу 245.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Тариалан сумын ИТХ-ын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 9/01 дүгээр тогтоолд зааснаар Тариалан сумын Засаг дарга тайлант онд 334.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 328.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 98.2 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 3.3 сая, хандив тусламжийн орлого 10.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3.7 сая, нийт 17.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 16.6 сая төгрөгийг зарцуулж 1.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 12.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,590.5 сая төгрөгийн 0.5 хувь буюу 12.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 10.4 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн нэгтгэсэн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн орлогоос 30.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авснаас шалтгаалан сумын орлого 6.1 сая төгрөгөөр тасарч орон нутгийн орлогын төлөвлөгөө 98.0 хувийн биелэлттэй гарсан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 79 мэдээллээс хугацаандаа оруулсан 77, хугацаа хоцроож 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  М.МӨНХТОГТОХ/

2023 оны 03 сарын 21-ны өдөр